



ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН  
ЗӨВЛӨХ "ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ  
МОНГОЛИА" ХХК

ШИФР: 02/23

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМ ДОТОРХ 1.6KM АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН  
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

ТАЙЛБАР БИЧИГ

УЛААНБААТАР  
2023 ОН

Захиалагч:



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯНМӨНХ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР

Зөвлөх:

**SRP**  
ENGINEER CONSULTING MONGOLIA LLC

"ЭС АР ПИ ИНЖЕНЕР  
КОНСАЛТИНГ МОНГОЛИА"  
ХХК

ШИФР: 02/23

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМ ДОТОРХ 1.6KM АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН  
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Т.УУГАНБАЯР

ЗУРГИЙН ИНЖЕНЕР:  Т.ЭРДЭНЭНЭМЭХ



УЛААНБААТАР  
2023 ОН

## АГУУЛГА

<b>БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>2</b>
1.1 Үндэслэл .....	2
1.2 Төслийн танилцуулга .....	2
1.3 Зөвлөх үйлчилгээний бүрэлдэхүүн .....	2
1.4 Зураг төслийн иж бүрдэл .....	3
1.5 Төлөвлөлтийн норм, дүрэм .....	3
1.6 Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд .....	4
<b>БҮЛЭГ ХОЁР. ТРАССЫН СУДАЛГАА .....</b>	<b>5</b>
2.1 Төлөвлөж буй авто замын өнөөгийн нөхцөл байдал .....	5
<b>БҮЛЭГ ГУРАВ. АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ .....</b>	<b>7</b>
3.1 Замын ангилал, төсөллөлтийн үзүүлэлтүүд .....	7
3.2 Трасс төлөвлөлт, хэвтээ төлөвлөлт .....	8
3.3 Дагуу огтлол төлөвлөлт .....	8
3.4 Хөндлөн огтлол төлөвлөлт .....	10
<b>БҮЛЭГ ДӨРӨВ. ХУЧИЛТЫН ТООЦОО .....</b>	<b>12</b>
4.1 Агуулга .....	12
4.2 Өгөгдөл .....	12
4.3 Дүгнэлт .....	15
<b>БҮЛЭГ ТАВ. УС ЗҮЙН СУДАЛГАА .....</b>	<b>18</b>
5.1 Ерөнхий мэдээлэл .....	18
5.2 УС ЗҮЙ .....	25
<b>БҮЛЭГ ЗУРГАА. ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>31</b>
6.1 Хөдөлгөөн зохион байгуулалт .....	31
6.2 Замын тоноглолд мөрдөх норм стандарт .....	31
6.3 Замын тэмдэг, тэмдэглэгээ .....	32
<b>БҮЛЭГ ДОЛОО. УУЛЗВАР, ГАРЦ, ЗОГСООЛЫН ТӨЛӨВЛӨЛТ .....</b>	<b>33</b>
7.1 Уулзвар, гарц .....	33
7.2 Зогсоол .....	34
<b>БҮЛЭГ НАЙМ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ .....</b>	<b>36</b>
8.1 Сургууль орчмын бүсийн хөдөлгөөний аюулгүй байдал .....	36
<b>БҮЛЭГ ЕС. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ .....</b>	<b>38</b>
9.1 Танилцуулга .....	38
9.2 Барилгын бэлтгэл ажил .....	38
9.3 Төслийн хэрэгжилт буюу зам барилгын ажил .....	38
9.4 Барилгын ажлын төлөвлөгөө .....	39
<b>БҮЛЭГ АРАВ. САНАМЖ .....</b>	<b>40</b>
<b>ХАВСРАЛТУУД .....</b>	<b>41</b>
ХАВСРАЛТ 1. Замын тэнхлэгийн координат .....	42
ХАВСРАЛТ 2. Замын тэмдэгний байршил .....	45
ХАВСРАЛТ 3. Газрын захирамж .....	48
ХАВСРАЛТ 4. Хучилтын тооцоо .....	49
ХАВСРАЛТ 5. Зураг төсөл боловсруулах даалгавар .....	61
ХАВСРАЛТ 6. “БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий Цахилгаан Түгээх сүлжээ” -с ирсэн техникийн нөхцөл .....	64
ХАВСРАЛТ 7. Ажлын тоо хэмжээ .....	67
ХАВСРАЛТ 8. Холбооны техникийн нөхцөл .....	69
ХАВСРАЛТ 9. Зөвшилцсөн нүүр .....	81
ХАВСРАЛТ 10. Инженер-геологийн тайлан .....	82
ХАВСРАЛТ 11. Инженер-геодезийн тайлан .....	99


## 1 БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Үндэслэл

- ✓ 2023 оны 04-р сарын 15-ны өдрийн Хэнтий аймаг, Баянмөнх сум доторх 1.6км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар
- ✓ Баянмөнх сум доторх хөдөлгөөний нөхцөл сайжирч, тоосжилт багасах, тав тухтай зорчих нөхцөл бүрдэнэ.

### 1.2 Төслийн танилцуулга

- ✓ Төслийн нэр: Хэнтий аймгийн Баянмөнх сум доторх 1.6км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл
- ✓ Байршил: Хэнтий аймаг, Баянмөнх сум
- ✓ Төслийн захиалагч байгууллага: Хэнтий аймгийн Баянмөнх сумын засаг даргын тамгын газар



Зураг 1.1 Авто замын трассын байршил

### 1.3 Зөвлөх үйлчилгээний бүрэлдэхүүн

“Хэнтий аймгийн Баянмөнх сум доторх 1.6км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл”-ийг боловсруулахад “Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа” ХХК-ийн баг нь авто замын геодези, зураглалын ажлын талбайн хэмжилт, хээрийн судалгааны ажлыг дараах бүрэлтхүүнтэйгээр ажиллалаа. Үүнд:

Ерөнхий гүйцэтгэгч:

- ✓ “Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа” ХХК

Туслан гүйцэтгэгч:

- ✓ Инженер - геологи, материалын судалгаа – “Талын хөрс” ХХК

- ✓ Инженер – геодези, байр зүйн зураглал – “Налуужим” ХХК

#### 1.4 Зураг төслийн иж бүрдэл

Инженерийн нарийвчилсан зураг төсөл нь доор дурьдсан иж бүрдэлтэй байна.

Үүнд:

- ✓ Боть-1 Ажлын зураг
- ✓ Боть-2 Тайлбар бичиг
- ✓ Боть-3 Техникийн шаардлага
- ✓ Боть-4 Геологийн тайлан
- ✓ Боть-5 Геодезийн тайлан
- ✓ Боть-6 Цахилгаан, гэрэлтүүлэг зураг төсөл, төсөв
- ✓ Боть-7 Холбооны шугамын техникийн зураг, төсөв
- ✓ Боть-8 Төсөв

#### 1.5 Төлөвлөлтийн норм, дүрэм

- ✓ Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016
- ✓ Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт БНБД 30-01-04
- ✓ Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12
- ✓ Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
- ✓ Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596-2014
- ✓ Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2014
- ✓ Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759 : 2014
- ✓ Геодези зурагзүйн тухай хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88;
- ✓ Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗХТ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэнэ.

## 1.6 Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд

Шинээр төлөвлөж буй авто замын зураг төслийн техникийн үндсэн үзүүлэлтүүдийг Хүснэгт 1.1-д үзүүлэв.

Хүснэгт 1.1 Төслийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Замын зэрэг	-	2А
2	Замын урт	км	1.6
3	Тойруугийн тоо	ш	-
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	-
5	Тойруугийн хамгийн их радиус	м	-
6	Тойруугийн нийт урт	м	-
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	-
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	10000
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	13500
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	-
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	-
12	Дагуугийн хамгийн их налуу	‰	
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	482
14	Зорчих хэсгийн өргөн	м	7.0
15	Хөвөөний өргөн	м	0.5
18	Далангийн хажуу налуу	m:n	1:1.5
19	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5
20	Хучлагын төрөл	-	капитал
21	Хучилтын хийц	-	Асфальтбетон

## 2 БҮЛЭГ ХОЁР. ТРАССЫН СУДАЛГАА

## 2.1 Төлөвлөж буй авто замын өнөөгийн нөхцөл байдал

Баянмөнх сумын гудамж замууд нь хөрсөн замаар холбогдсон.

Төлөвлөж буй автозамын 1-р хэсэг нь Цац 2-р гудамжнаас зүүн хойш уурын зуух хүртэл 0.66км, трассын 2-р хэсэг нь ЕБС-ийн зүүн урд 4 замын уулзвараас хойш цэцэрлэгт хүрээлэн хүртэл 0.35км, трассын 3-р хэсэг цэцэрлэгт хүрээлэнгээс хэрлэн голын гүүрийн урд зам хүртэл 0.48км байхаар төлөвлөгдсөн.



Зураг 2.1 Одоо байгаа байдал/Трасс-1/



Зураг 2.2 Одоо байгаа байдал/Трасс-2/



Зураг 2.3 Одоо байгаа байдал/Трасс-3/



Зураг 2.4 Одоо байгаа байдал/Зогсоол-2/



## 3 БҮЛЭГ ГУРАВ. АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ

## 3.1 Замын ангилал, төсөллөлтийн үзүүлэлтүүд

Авто замыг төлөвлөж төлөвлөлтийн стандартуудыг сонгохдоо хөдөлгөөний эрчим, замын зэрэглэл, газар нутгийн байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Бүх геометр төлөвлөлтийг хийхдээ “Авто зам төсөллөх” ЗБНБД 22-004-2016 мөрдлөг болгосон. Төлөвлөж буй замын техникийн ангилал, зэрэг нь “Авто зам төсөллөх” ЗБНБД 22-004-2016 стандартын дагуу хуримтлуулагч – 2А байна.

**Хуримтлуулагч зам – 2А** – Хуримтлуулагч замын үүрэг нь хэд хэдэн бүс, нутаг дэвсгэрээр өнгөрөх замын болон дүүргийн доторхи мөн томоохон суурин газруудын хөдөлгөөний хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

**Хүн ам** – 1000-аас дээш хүн амтай суурин болон жуулчдын зорьдог газруудын хэрэгцээг хангах.

**Хөдөлгөөний эрчим** – жилийн хоногийн хөдөлгөөний дундаж эрчим 200-аас дээш, түүний 35-аас илүүгүй хувийг ачааны авто машин болон амралт, аялал, зугаалгаар яваа тээврийн хэрэгсэл эзлэх. Зам дээр өнгөрөх тээврийн хэрэгслийн 35-аас илүү хувийг ачааны машин болон амралт, аялал, зугаалгын зориулалттай тээврийн хэрэгсэл эзлэх бол уг замыг 2Б зэрэглэлийн /хуримтлуулагч, тусгай зам/ замд тооцно.

**Сүлжээний үргэлжлэх байдал** – 1А, 1Б, 1В,1Г зэрэглэлийн замуудын сегмент хоорондын сүлжээнд үүсэх тасалдалыг бууруулах. Тухайн бүс нутаг, хүн ам суурьшсан бүх хот, суурин, тосгон руу салах, тэндээс төв зам руу орох боломжоор хангах.

*Хүснэгт 3.1 Замын тооцоот хурд*

Үндэслэл	Замын ангилал	Замын зэрэглэл	Замын нэршил	Замын тооцоот хурд, км/цаг		
				Тал газар	Нугачаатай газар	Уулархаг газар
“Авто зам төсөллөх” ЗБНБД 22-004-2016	Хуримтлуулагч зам	2А	Хөдөө нутгийн хуримтлуулагч зам	80	60	50

*Хүснэгт 3.2 Хөдөлгөөний зурвас болон замын өргөн*

Замын ангилал	Хөдөлгөөний зурвасын тоо	Зурвасын өргөн, м	Зорчих хэсгийн өргөн, м	Явган замын өргөн, м
Хуримтлуулагч зам	2	3.5	7	≥1.2

*Хүснэгт 3.3 Үзэгдэлтийн зай*

Тооцоот хурд км/ц	Зогсох үеийн үзэгдэлтийн зай, м	Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэлтийн зай, м
50	65	160
60	85	180
80	130	245

Гадаргуугийн төрөл	2А		
	Тооцоот хурднаас хамаарсан хамгийн их дагуу налуу %		
	Төсөллөлтийн тооцоот хурд, км/ц		
	50	60	80
Тэгш	7	7	6
Нугачаатай	9	8	7
Уулархаг	10	10	9

### 3.2 Трасс төлөвлөлт, хэвтээ төлөвлөлт

Зургийн ажлын даалгаварын дагуу шинээр төлөвлөж буй авто замыг сумын төвийн авто замын сүлжээнд уялдуулан төлөвлөв.

### 3.3 Дагуу огтлол төлөвлөлт

Төлөвлөж буй авто зам нь суурьшлын бүс нутагт оршино.

Авто замын дагуу огтлол төлөвлөлтийг ЗЗБНБД 22-004-2016-ийн дагуу IndorCAD/Road программ хангамж ашиглан хийж гүйцэтгэв. Трассын дагуу элемент, параметруудийг доорх хүснэгтүүдээр үзүүлэв.

Хүснэгт 3.5 Дагуу огтлолын элемент/Трасс-1/

ПК+	Газрын түвшин, м	Төлөвлөлтийн түвшин, м	Ажлын өндөр, м	Интерполяцийн ажлын өндөр, м	Налуу, ‰	Радиус, м
0+000.000	1114.396	1114.336	-0.060	1114.396	-25	—
0+014.649	1114.484	1114.389	-0.095	1114.484	14	—
0+020.000	1114.449	1114.466	0.017	1114.448	14	—
0+024.098	1114.432	1114.524	0.092	1114.432	14	—
0+040.000	1114.480	1114.751	0.271	1114.480	14	—
0+060.000	1114.780	1115.026	0.246	1114.780	13	13500
0+080.000	1115.056	1115.272	0.216	1115.056	12	13500
0+100.000	1115.246	1115.488	0.242	1115.247	10	13500
0+120.000	1115.382	1115.675	0.293	1115.382	9	13500
0+140.000	1115.580	1115.832	0.252	1115.580	7	13500
0+160.000	1115.718	1115.960	0.242	1115.718	6	13500
0+180.000	1115.667	1116.057	0.390	1115.667	4	13500
0+184.378	1115.691	1116.075	0.384	1115.691	4	13500
0+200.000	1115.879	1116.127	0.248	1115.879	3	—
0+220.000	1115.845	1116.189	0.344	1115.845	3	—
0+240.000	1115.861	1116.251	0.390	1115.861	3	—
0+260.000	1115.969	1116.313	0.344	1115.969	3	—
0+280.000	1115.933	1116.375	0.442	1115.933	3	—
0+300.000	1115.874	1116.437	0.563	1115.874	3	—
0+320.000	1115.912	1116.499	0.587	1115.912	3	—
0+336.055	1116.072	1116.549	0.477	1116.072	3	—
0+340.000	1116.093	1116.561	0.468	1116.093	3	—
0+350.015	1116.115	1116.592	0.477	1116.115	3	—
0+352.822	1116.100	1116.601	0.501	1116.100	3	—
0+356.940	1116.152	1116.614	0.462	1116.152	3	—

0+360.000	1116.185	1116.623	0.438	1116.185	3	—
0+380.000	1116.208	1116.685	0.477	1116.208	3	—
0+397.680	1116.227	1116.740	0.513	1116.227	3	—
0+400.000	1116.239	1116.747	0.508	1116.240	3	—
0+420.000	1116.313	1116.809	0.496	1116.313	3	—
0+433.060	1116.319	1116.850	0.531	1116.319	3	—
0+435.320	1116.333	1116.857	0.524	1116.332	3	—
0+440.000	1116.346	1116.871	0.525	1116.346	3	—
0+446.940	1116.389	1116.893	0.504	1116.389	3	—
0+450.000	1116.388	1116.902	0.514	1116.389	3	—
0+453.982	1116.417	1116.915	0.498	1116.416	3	—
0+460.000	1116.467	1116.933	0.466	1116.468	3	—
0+464.210	1116.516	1116.946	0.430	1116.517	3	—
0+464.310	1116.515	1116.947	0.432	1116.515	3	—
0+480.000	1116.556	1116.995	0.439	1116.557	3	—
0+500.000	1116.699	1117.057	0.358	1116.700	3	—
0+511.385	1116.853	1117.093	0.240	1116.853	3	—
0+511.585	1116.856	1117.093	0.237	1116.856	3	—
0+520.000	1116.847	1117.119	0.272	1116.847	3	—
0+533.190	1116.873	1117.159	0.286	1116.873	3	10000
0+540.000	1116.949	1117.174	0.225	1116.949	2	10000
0+551.500	1117.057	1117.190	0.133	1117.056	1	10000
0+560.000	1117.068	1117.192	0.124	1117.068	0	10000

Хүснэгт 3.6 Дагуу огтлолын элемент/Трасс-2/

ПК+	Газрын түвшин, м	Төлөвлөлтийн түвшин, м	Ажлын өндөр, м	Интерполяцийн ажлын өндөр, м	Налуу, %	Радиус, м
0+000.000	1116.633	1117.024	0.391	1116.633	20	—
0+020.000	1116.427	1116.833	0.406	1116.427	-16	—
0+024.656	1116.325	1116.760	0.435	1116.325	-16	—
0+040.000	1116.052	1116.518	0.466	1116.052	-16	—
0+050.000	1115.901	1116.361	0.460	1115.901	-16	—
0+055.000	1115.797	1116.282	0.485	1115.797	-16	—
0+060.000	1115.767	1116.203	0.436	1115.767	-16	—
0+070.000	1115.685	1116.046	0.361	1115.685	-16	—
0+080.000	1115.675	1115.888	0.213	1115.675	-16	—
0+100.000	1115.412	1115.573	0.161	1115.412	-16	—
0+120.000	1115.243	1115.258	0.015	1115.243	-16	—
0+140.000	1114.828	1114.944	0.116	1114.828	-16	—
0+160.000	1114.442	1114.629	0.187	1114.441	-16	—
0+163.399	1114.415	1114.575	0.160	1114.415	-16	—
0+177.239	1114.214	1114.357	0.143	1114.214	-16	—
0+180.000	1114.174	1114.314	0.140	1114.173	-16	—
0+200.000	1113.815	1113.999	0.184	1113.814	-16	—
0+220.000	1113.309	1113.684	0.375	1113.309	-16	—
0+240.000	1113.084	1113.369	0.285	1113.084	-16	—
0+260.018	1112.699	1113.054	0.355	1112.698	-16	—
0+280.000	1112.440	1112.739	0.299	1112.440	-16	—
0+300.000	1112.110	1112.424	0.314	1112.110	-16	—

0+320.000	1111.981	1112.109	0.128	1111.981	-16	—
0+338.416	1111.665	1111.819	0.154	1111.665	-16	—
0+340.018	1111.650	1111.794	0.144	1111.650	-16	—
0+340.356	1111.647	1111.788	0.141	1111.647	-16	—
0+357.903	1111.414	1111.496	0.082	1111.414	-20	—


Хүснэгт 3.7 Дагуу огтлолын элемент/Трасс-3/

ПК+	Газрын түвшин, м	Төлөвлөлтийн түвшин, м	Ажлын өндөр, м	Интерполяцийн ажлын өндөр, м	Налуу, %	Радиус, м
0+000.000	1111.173	1111.152	-0.021	1111.173	9	—
0+020.000	1111.217	1111.324	0.107	1111.216	9	—
0+022.116	1111.198	1111.342	0.144	1111.197	9	—
0+040.000	1111.415	1111.496	0.081	1111.414	9	—
0+059.487	1111.498	1111.663	0.165	1111.499	9	—
0+060.000	1111.499	1111.668	0.169	1111.498	9	—
0+080.000	1111.512	1111.832	0.320	1111.512	7	10000
0+100.000	1111.434	1111.959	0.525	1111.434	5	10000
0+120.000	1111.335	1112.046	0.711	1111.334	3	10000
0+140.000	1111.255	1112.093	0.838	1111.255	1	10000
0+160.000	1111.356	1112.099	0.743	1111.356	-1	10000
0+180.000	1111.361	1112.066	0.705	1111.362	-3	10000
0+200.000	1111.364	1111.993	0.629	1111.365	-5	10000
0+220.000	1111.308	1111.880	0.572	1111.308	-6	—
0+230.626	1111.272	1111.811	0.539	1111.272	-6	—
0+232.349	1111.276	1111.800	0.524	1111.276	-6	—
0+240.000	1111.335	1111.750	0.415	1111.336	-6	—
0+260.000	1111.215	1111.620	0.405	1111.215	-6	—
0+267.666	1111.150	1111.570	0.420	1111.151	-6	—
0+269.388	1111.141	1111.559	0.418	1111.141	-6	—
0+280.000	1111.076	1111.490	0.414	1111.076	-6	—
0+300.000	1111.043	1111.360	0.317	1111.043	-6	—
0+320.000	1110.881	1111.230	0.349	1110.882	-6	—
0+340.000	1110.612	1111.088	0.476	1110.612	-8	10000
0+360.000	1110.657	1110.906	0.249	1110.658	-10	10000
0+380.000	1110.238	1110.685	0.447	1110.238	-12	10000
0+400.000	1109.985	1110.425	0.440	1109.984	-14	—
0+420.000	1109.823	1110.154	0.331	1109.823	-14	—
0+440.000	1109.543	1109.883	0.340	1109.543	-14	—
0+459.926	1109.246	1109.613	0.367	1109.246	-14	—
0+466.860	1109.220	1109.519	0.299	1109.220	-14	—
0+480.000	1109.308	1109.321	0.013	1109.309	-19	—
0+482.191	1109.291	1109.291	0.000	1109.291	-19	—


### 3.4 Хөндлөн огтлол төлөвлөлт

Хөндлөн огтлолын овор хэмжээг “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 – ийн дагуу тооцож, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайтар анхааран суурин газар болон орон нутгийн нөхцөл байдал, гарц, орц, огтлолцож буй одоо байгаа зам зэргийг харгалзан үзэж сонгож төсөллөв.


ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨРӨЛ - 1



ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨРӨЛ - 2




ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨРӨЛ - 3



Зураг 3.1 Авто замын нэг маягийн хөндлөн огтлолын төрлүүд

ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨРӨЛ - 4



Зураг 3.2 Зогсоолтой хэсгийн нэг маягийн хөндлөн огтлол

## 4 БҮЛЭГ ДӨРӨВ. ХУЧИЛТЫН ТООЦОО

## 4.1 Агуулга

Авто замын хучилтын хийцийг төсөллөхдөө Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016 норм ба дүрмийн 15 дугаар бүлэгт заасны дагуу ОХУ-ын “Отраспевые дорожные нормы проектирование нежестих дорожных одежд” ОДН 2018.046-01-ын аргачлалаар IndorPavement программ хангамж ашиглаж тооцоог гүйцэтгэсэн болно.

Мөн хавсралт хэсэгт програмаас авсан эх тайланг орос хэл дээр байгаа байдлаар үзүүлэв.

## 4.2 Өгөгдөл

Өнөөгийн хөдөлгөөний эрчмийн тооллого, тэнхлэгийн ачаалал даацын судалгаа, хөдөлгөөний эрчмийн хэтийн төлөвөөс үндэслэн төслийн замд хучилтын хийцийн дараах дараах хувилбарыг хийсэн болно. Хучилтын тооцоо хийсэн суурь өгөгдөлүүдийг хүснэгт дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4.1 Хучилтын тооцооны өгөгдөл

Хучилтын тооцоонд ашигласан өгөгдөл:	Үзүүлэлтүүд
Хийгдсэн тооцоонууд	Уян харимхайн хотойлт, гулсалт, гулзайлт
1.Тэнхлэг тус бүр дээр ирэх ачаалал	
Монгол улсын стандарт MNS 4598:2011-д заасан ачаатай бүх жин 44тн, хөтлөгч нэг тэнхлэг дээр ирэх ачаалал 11.0тн, хөтлөгдөх тэнхлэг дээр 10.0тн	
2.Цаг уурын мэдээлэл	
Төсөллөлтийн бүс нутаг	Хэнтий аймаг
Зам цаг уурын бүс	IIВ
Газрын гадарга	Тал хээр
Цаг агаарын таагүй өдрүүдийн тоо	125
Хөрсний нягтруулалтын итгэлцүүр	1.02
Хөлдөлтийн гүн	1.38м
Дундаж температур	4.4
Хөрсний тооцоот чийг Wp	0.74
3.Замын өгөгдлүүд	
Замын зэрэг	“Хуримтлуулагч зам”
Зурвасын тоо	2
Замын хучилтын төрөл	капитал
Ашиглалтын тооцоот хугацаа Tсл	15 жил
Хөдөлгөөний эрчим өсөлт	2%

Эхний жилийн хөдөлгөөний эрчим	2848 хон/маш
Суудлын автомашин	1925
Бага даацын авто машин 1-5т:	518
Дунд даацын авто машин 5 - 8 т:	345
Хүнд даацын авто машин 8 т дээш	17
Автобус:	43
Нэг зурвас дахь тооцоот хугацааны турш ирэх стандарт ачаалал /машин/	707336 маш
Хамгийн бага шаардлагатай уян харимхайн модуль, МПа	296 МПа
Жилд ашигдагдах өдрийн тоо Трдг	250
5. Тооцоот ачаалал 44 тн	
Дугуйн төрөл	давхар
Нэг тэнхлэг дээрхи ачаалал	110 кН
Нэг тэнхлэг дээрхи тооцоот ачаалал	110 кН
Дугуйн даралт	0.80 МПа
Дугуйн мөр D (дин.)	39 см
Найдвар байдал итгэлцүүр Kp	0.95
Хөндлөн огтлол	2 тийш налуутай
Зурвасын өргөн	3,5 м
Хөвөөний өргөн	өргөн 1.5*2
Хажуу налуу	1:2.0
Далангийн өндөр	<1.0м
Далангийн хөрс	Элс ба шавартай жигд бус ширхэглэлтэй хөрс
Ул хөрс	Элсэнцэр
Нягтралын коэфф	0.98
Тооцоот чийглэг	0.7
Тооцоот чийгийн тооцоо	2-р хэлбэр (Хур тундас ихтэй)
4. Хөдөлгөөний эрчим	
Машины төрөл	Стандарт тээврийн хэрэгсэл

Зөвлөхөөс дараах хучилтын хийцийн хувилбарыг санал болгож тооцоот хугацаанд хуримтлах хөдөлгөөний ачааллыг даах эсэхийг ОХУ-д боловсруулсан “INDor

PAVE” хучилтийн даацын тооцооны программ ашиглан шалгасан. Эхний жилийн хөдөлгөөний эрчмийн тооцоонд төслийн зам дагуух Баянмөнх, Баянхутаг, Дархан, Бор Өндөр сумуудын 2021 онд тоологдсон тээврийн хэрэгсэлийн тооллогын дүнд үндэслэсэн болно.

Хучилтын хийц

1. 3 см зузаантай өнгө асфальтбетон
2. 4 см зузаантай суурь асфальтбетон
3. 20 см зузаантай цементээр бэхжүүлсэн суурь
4. 30 см зузаантай зохист бүрэлдэхүүнтэй байгалийн хайрган дэвсгэр үе


Нийт 57см зузаан хучлагатай болно.

Өгөгдөл

Объектын нэр	Бор Өндөр-Хэрлэн чиглэлийн авто зам		
Төсөллөлтийн бүс нутаг	Хэнтий аймаг		
Хийгдэх тооцоолууд	Уян харимхайн хотойлт, гулсалт, гулзайлт, хөлдөлт		
Замын зэрэг	Хуримтлуулах	Хучилтын схем	Төрөл 1
Замын хучилтын төрөл	Капиталь	Хөрсний нягтын коэффициент	0.97
Зурвасын тоо	2	Шаардлагатай уян харимхайн модуль, МПа	298
Тооцоолох зурвас /хөвөө талаас/	1	Тооцрот хугацааны турш ирэх стандарт ачаалал	707336
Тооцрот чийглэг Wp	0.76	Жилд ашиглагдах өдрийн тоо Трдг	250
Танхлаг ачаалал Кн Дугуйн даралт, МПа Дугуйн мөр D, см	110 / 0.80 / 39	Ашиглалтын тооцрот хугацаа, жил	15
Найдавартай байдлын итгэлцүүр Кн	0.95	Замын байгууламжийн хөлдөлтийн гүн, м	1.38
Зам цаг уурын бүс	IV		

Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Хөдөлгөөний эрчим Маш/хн	Шилжих коэффициент	Шилжсэн эрчим
1	Суудлын автомашин 1 т	1925	0.003	5.775
2	Бага даацын ачааны автомашин 2 т	518	0.13	67.34
3	Дунд даацын ачааны автомашин 5 до 8 т	345	0.46	158.7
4	Хүнд даацын ачааны автомашин 8 т дээш	17	0.82	13.94
5	Автобус	43	0.46	19.78
6	нийт	2848		265.535




Хөдөлгөөний эрчмийн есөлт: 1.04  
Нэг зурвас дахь тооцрот хугацааны турш ирэх стандарт ачаалал: 707336  
Шаардлагатай уян харимхайн модуль, МПа: 298

№	Хучилтын нэр материалын хамт	Хучилтын хийц, зузаан см	Уян харимхайн модуль МПа	Хучилтын тооцооны үзүүлэлтүүд				Хөлдөлт
				Хотойлт МПа	Гулсалт, МПа	Гулзайлт, МПа	Статик ачаалал	
Версия №1	1. Өнгө асфальт хучлага — БНД 90/130 маркийн буюу үүнтэй ижил төсөөтэй битумээр зуурсан, 1 м аркийн нягттай буталсан чулуун, халуунаар дэвсэх хольц.	1	Eпов = 380	Eупр = 2400 Ктр = 1.170 Красч = 1.280 Запас = 9%	Eсдв = 1200	Eизг = 4800	Eстат = 480 МПа	
	2. Суурь асфальт хучлага — БНД 90/130 маркийн буюу үүнтэй ижил төсөөтэй битумээр зуурсан, 1 м аркийн нягттай буталсан чулуун, халуунаар дэвсэх хольц.	2	Eпов = 381	Eупр = 2400	Eсдв = 1200	Eизг = 4800 Ктр = 1.000 Красч = 1.912 Запас = 91%	Eстат = 480 МПа	
	3. ЦБСуурь — Цементээр бэхжүүлсэн суурь (4-6% цемент)	3	Eпов = 331	Eупр = 800	Eсдв = 800	Eизг = 800	Eстат = 800 МПа	
	4. Хайрган суурь — Зохист бүрэлдэхүүнтэй хайрган дэвсгэр үе: 37.5 мм хүртэл хэмжээтэй шигд ширхэглэл бүхий байгалийн хайрган материал.	4	Eпов = 196	Eупр = 280	Eсдв = 280	Eизг = 280	Eстат = 280 МПа	
	Далан — том ширхэглэлтэй өлсөн жөрс		Eпов = 130	Eупр = 130 Eсдв = 130 Ктр = 1.000 Красч = 1.110 Запас = 11%	Eсдв = 130 Ктр = 1.000 Красч = 2.350 Запас = 135%	Eизг = 130 МПа	Eстат = 130 МПа Ктр = 1.000 Красч = 2.350 Запас = 135%	Lдон = 4 см Lгум = 1 см Запас = 2 см

Зураг 4.1 Хучилтын хийцийн тооцооны үзүүлэлт





1. Construction layer № 1 — Асфальтобетон горячей укладки плотный I марки, из щебёночной (гравийной) смеси типа В, марка битума БНД/БН-90/130
2. Construction layer № 2 — Асфальтобетон горячей укладки плотный I марки, из щебёночной (гравийной) смеси типа А, марка битума БНД/БН-90/130
3. Construction layer № 3 — Щебень фракционированный 40..80 (80..120) мм легкоуплотняемый с заклиной фракционированным мелким щебнем
4. Construction layer № 4 — Смеси гравийные с непрерывной гранулометрией С5 - 40 мм (для оснований)

Зураг 4.2 Хучилтын хийц

### 4.3 Дүгнэлт

Дээрх тооцооноос харахад хучилтын хийцийн тооцооны 2 хувилбар хангагдсан байна. Хучилтын хийцийн тооцооны 2 хувилбар доорх 5-н шалгуурыг хангасан байна.

#### 1. Уян харимхайн модуль /бат бөх/

Гадаргуугийн уян харимхайн модуль  $E_{пов} = 379.7$  МПа  
 Шаардлагатай уян харимхайн модуль  $E_{тр} = 296.1$  МПа  
 Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр  $K_{расч} = 1.280$   
 Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр  $K_{тр} = 1.170$   
 Бат бэхийн нөөц  $(K_{расч} - K_{тр}) / K_{тр} * 100\% = 9\%$  (Хангалттай байна.)

#### 2. Гулсалтын эсэргүүцэл

Замын далангийн хөрс  
 Материалын үзүүлэлтүүд  
 Элс ба шавартай, жигд бус ширхэглэлтэй хөрс  
 Дотоод үрэлтийн өнцөг  $\varphi = 28.3^\circ$   
 Барьцалдах хүч  $c_n = 0.003$  МПа  
 Статик дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{ст} = 42,0^\circ$   
 Итгэлцүүр  $K_d = 2.0$   
 Хоёр үетэй загварын үзүүлэлтүүд  
 Дээд үеүүдийн дундчилж авсан уян харимхайн модуль  $E_v = 575.44$  МПа  
 Тооцоот үеийн гадаргуу дахь уян харимхайн модуль  $E_n = 130,0$  МПа  
 Дээд үеүүдийн дундчилж авсан хувийн жин  $\gamma = 0.0018$  МПа  
 Тооцоот үеийн орших гүн  $Z_{оп} = 57.0$  см

Гулсалтын нэгж идэвхтэй хүчдэл  $\tau = 0.02719 \text{ МПа}$   
 Гулсалтын тооцоолсон идэвхтэй хүчдэл  $T = 0.022 \text{ МПа}$   
 Гулсалтын туйлын идэвхтэй хүчдэл  $T_{\text{пр}} = 0.02415 \text{ МПа}$   
 Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр  $K_{\text{расч}} = 1.110$   
 Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр  $K_{\text{тр}} = 1.000$   
 Бат бэхийн нөөц  $(K_{\text{расч}} - K_{\text{тр}}) / K_{\text{тр}} * 100\% = 11\%$  (Хангалттай байна.)

### 3. Гулзайлтын үеийн эсэргүүцэл

Материалын үзүүлэлтүүд  
 БНД 90/130 маркийн буюу үүнтэй ижил төсөөтэй битумээр зуурсан, I маркийн нягт, А төрлийн буталсан чулуун, халуунаар дэвсэх асфальтбетон хольц  
 Хаврын нормативт эсэргүүцэл  $R_0 = 9.5 \text{ МПа}$   
 Зэргийн цуцалтын үзүүлэлт  $m = 5.0$   
 Ялгааны итгэлцүүр  $\alpha = 5.4$   
 Бат бэхийн бууралтын итгэлцүүр  $k_2 = 0.9$   
 Хоёр үетэй загварын үзүүлэлтүүд  
 Цулжсан үеүүдийндундчилж авсан уян харимхайн модуль  $E_v = 4600.0 \text{ Мпа}$   
 Цулжсан үеүүдийндоторх доод үеийн гадаргуу дахь уян харимхайн модуль  
 $E_{\text{обш}} = 331.23 \text{ Мпа}$   
 Тооцоот үеийн орших гүн  $Z_{\text{оп}} = 7.0 \text{ см}$   
 Итгэлцүүр  $K_v$  (хос дугуйны)  $= 0.85$   
 Эцэлтээс үүдсэн эвдрэлийн итгэлцүүр  $k_1 = 0.37$   
 Хамгийн их сунгах хүчдэл  $\sigma_r = 1.504 \text{ МПа}$   
 Материалын гулзайлтын үеийн бат бэх  $R_n = 2.876 \text{ МПа}$   
 Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр  $K_{\text{расч}} = 1.912$   
 Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр  $K_{\text{тр}} = 1.000$   
 Бат бэхийн нөөц  $(K_{\text{расч}} - K_{\text{тр}}) / K_{\text{тр}} * 100\% = 91\%$  (Хангалттай байна.)

### 4. Статистик ачааллын үйлчлэлийн бат бөх

Замын далангийн хөрс  
 Материалын үзүүлэлтүүд  
 Элс ба шавартай, жигд бус ширхэглэлтэй хөрс 5%  
 Барьцалдах хүч  $c_n = 0.005 \text{ МПа}$   
 Статик дотоод үрэлтийн өнцөг  $\varphi_{\text{ст}} = 42.0^\circ$   
 Итгэлцүүр  $K_d = 2.0$   
 Хоёр үетэй загварын үзүүлэлтүүд  
 Дээд үеүүдийн дундчилж авсан уян харимхайн модуль  $E_v = 487.02 \text{ МПа}$   
 Тооцоот үеийн гадаргуу дахь уян харимхайн модуль  $E_n = 130.0 \text{ МПа}$   
 Дээд үеүүдийн дундчилж авсан хувийн жин  $\gamma = 0.0018 \text{ МПа}$   
 Тооцоот үеийн орших гүн  $Z_{\text{оп}} = 57.0 \text{ см}$   
 Гулсалтын нэгж идэвхтэй хүчдэл  $\tau = 0.01496 \text{ МПа}$   
 Гулсалтын тооцоолсон идэвхтэй хүчдэл  $T = 0.012 \text{ МПа}$   
 Гулсалтын туйлын идэвхтэй хүчдэл  $T_{\text{пр}} = 0.02815 \text{ МПа}$

Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр  $K_{расч} = 2.350$

Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр  $K_{тр} = 1.00$

Бат бэхийн нөөц  $(K_{расч}-K_{тр})/K_{тр} * 100\% = 135\%$  (Хангалттай байна.)

#### 5. Хүйтэн тэсвэрлэлт

(Хучилтын доод хэсэг хүртэл) газрын доорхи усны гүн  $R_n \approx 10.43$  м

Хөрсний усны түвшинг тооцсон итгэлцүүр  $K_{угв} = 0.42$

Дээд талд байгаа үеүүдээс ирэх ачааллыг тооцсон итгэлцүүр  $K_{нагр} = 1.07$

Үеийн нягтруулалтаас хамаарах итгэлцүүр  $K_{пл} = 1.16$

Суурийн ширхэглэлийг тооцсон итгэлцүүр  $K_{гр} = 1.10$

Дундаж нөхцөлд үүсэх магадлалтай хүйтний

Овойлтын хэмжээ  $L_{пуч.ср.} = 1038$  см

(Хөрсөнд үүсэх овойлт  $0.79\text{см} < \text{зөвшөөрөгдөх хэмжээ } 4.0\text{ см}$ )

Тухайн хийц нь хүйтэнд тэсвэрлэхээр байна.

Тооцооны үр дүнг нэгтгэж үзвэл сонгосон хучилтыг хийсэн үед хучилтын даац, бат бэхийн үзүүлэлт, гузайлтын үзүүлэлтүүд нь шаардлага хангах түвшинд байна. Хучилтын тооцооны үзүүлэлтүүдийн нөөц нь хангалттай байна.

## 5 БҮЛЭГ ТАВ. УС ЗҮЙН СУДАЛГАА

## 5.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймаг Баянмөнх сумын доторх 1.6км авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн ажлын хүрээнд ус зүйн судалгаа, гидрологийн тооцоог “Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа” ХХК хийж гүйцэтгэлээ.

## 5.1.1 Төслийн тодорхойлолт

Тодорхойлох зүйл	Тайлбар
Төслийн нэр	Хэнтий аймгийн Баянмөнх сумын доторх 1.6км авто замын ус зүйн судалгаа, гидрологийн тооцоо
Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Хэнтий аймгийн Баянмөнх сумын ЗДТГ-тай байгуулсан зураг төсөл боловсруулах ажлын гэрээ</li> <li>- Хэнтий аймгийн Баянмөнх сумын ЗДТГ боловсруулсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар</li> </ul>
Төсөл хэрэгжүүлэх газрын нэр	Хэнтий аймаг Баянмөнх сум
Төсөл боловсруулах байгууллага	“Эс Ар Пи Инженер Консалтинг” ХХК
Төслийн үр дүн	Баянмөнх сумын төвийн авто зам дагуу борооны усыг цуглуулах, зайлуулах сувгийн урсацыг тодорхойлох, иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж байгаа явцыг зогсоох.
Ус зүйн гидрологийн тооцоо боловсруулах норм	БНБД 2.01.14-86 “Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм” дагуу хийж гүйцэтгэсэн.

## 5.1.2 Төслийн байршил

Судалгааны төслийн талбай болох Хэнтий аймаг, Баянмөнх сум нь газар зүйн байрлалын хувьд Халхын дундад ба Дарьгангын талархаг мужид Халхын дундад ухаа гүвээт тал тойрогт багтаж далайн түвшнээс дээш 1110 м-ийн өндөрт, Улаанбаатар хотоос ойролцоогоор 434км зайд байрладаг. Ус зүйн хувьд Номхон далайн ай савд Хэрлэн голын ус хурах талбайд оршино.



Зураг 5.1 Замын зурвасын байршлын байр зүйн зураг

### 5.1.3 Уул зүйн нөхцөл

Судалгаанд хамрагдаж буй районд зонхилж ухаа гүвээт тал, талархаг гадаргатай.

### 5.1.4 Хөрс ургамлын нөхцөл

Судалгааны район нь хөрсний ангилалаар Монголын Дорнод талын их мужид Монголын дорнод мужийн хээрийн хүрэн хөрсний бүсэд Өндөрхааны районд хамаарагдаж хөрсөн бүрхэвчинд хээрийн хүрэн, хээрийн бор шаргал хөрс зонхилж тархана. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн нийт талбайд элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уур амьсгалын нөлөөгөөр хээрийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш ядмаг байдаг.

### 5.1.5 Ус зүйн нөхцөл

Төлөвлөж буй зам нь Номхон далайн ай савд багтах Хэрлэн голын урсгалын чиглэлээр баруун гар талд орших ба нийт уртад гадаргын ус ховортой.

### 5.1.6 Уур амьсгалын нөхцөл

Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (цас багавтар унаж хахир хүйтэрнэ), зун нь богино (хур тунадас багавтар ордог, үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг),

хавар, намар хөндий дагасан хүчтэй шуургатай өдөр олон тохиолддог, чийглэг нэн сэрүүн бичил мужид хамаарна.

Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Баянмөнх, Өндөрхаан станцын олон жилийн ажиглалтын материалыг ашиглан агаарын температур, агаарын чийгшил хур тунадас, салхины горим гэсэн үзүүлэлтээр өгч хүснэгтээр харуулав.

#### 5.1.7 Агаарын температур

Өндөрхаан өртөөний олон жилийн агаарын температур  $-0.7^{\circ}\text{C}$  байгаа нь сэрүүвтэр бүсэд багтахыг харуулна. Агаарын температур хавар 4-р сарын эхний арав хоногт  $0^{\circ}\text{C}$ -ийг давж дулаарч, хамгийн дулаан 7-р сард  $+16$ -аас  $+19^{\circ}\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй их нь  $+35$ -өөс  $+38^{\circ}\text{C}$  байна. Намар 10-р сарын сүүл арав хоногт  $0^{\circ}\text{C}$ -ийг давж хүйтэрч, хамгийн хүйтэн 1-р сард  $-15^{\circ}\text{C}$ -ээс  $-20^{\circ}\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй бага нь  $-36.0$ -оос  $-40.0^{\circ}\text{C}$  байна. Агаарт цочир хүйтрэлт жил болгон ажиглагдахгүй боловч олон жилийн дундажаар цочир хүйтрэлт ажиглагдах анхны хугацаа нь намар 9-р сарын дунд арав хоногт, эцсийн хугацаа нь хавар 5-р сарын эхээр ажиглагдаж цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 120 орчим хоног байна.

#### 5.1.8 Хөрсний температур

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур  $+2.2$ -оос  $+3.6^{\circ}\text{C}$  байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил хөрсний гадаргын температурын үнэмлэхүй хамгийн дулаан  $58-59^{\circ}\text{C}$  хүрч, үнэмлэхүй хамгийн хүйтэн  $-40.0^{\circ}\text{C}$ -  $-42.0^{\circ}\text{C}$  хүйтэн, үнэмлэхүй хамгийн их, бага температурыг агууриг  $105-118^{\circ}\text{C}$  байдаг. Хөрсний өнгөн давхаргын 5; 10; 15; 20 см гүнд 4-р сарын сүүлчээс 9-р сарын сүүлч хүртэл нэмэх утгатай байна. Газрын гүнд температурын хувиарлалт нь тодорхой зүй тогтолтой. Зуны улиралд гүн ихсэхээр температур буурч, өвлийн улиралд гүн рүүгээ дулаарч, хавар, намар шилжилтийн байдалтай. Тухайлбал 4, 10-р сард дунд гүн (0.8;1.2м) дулаан, хоёр тийшээ сэрүүссэн явцтай байна. Өндөрхаан станцад зуны 7-8-р сард  $20^{\circ}$ -ын изотерм 5-10 см-ийн гүнд,  $15^{\circ}$ -ынх 40 см-ийн гүнд,  $10^{\circ}$ -ын изотерм 8-9-р сард 1.25 м гүнд,  $5^{\circ}$ -ынх 10-р сард 2.5 м-ийн гүнд тус тус тархсан байна.  $0^{\circ}$ -ын изотерм 4-р сард 2.90-3.0 м хүртэл гүнд,  $-5^{\circ}$ -ынх 3-р сард 1.7 м-ийн гүнд,  $-10^{\circ}$ -ынх 1.0 м-ийн гүнд,  $-15^{\circ}$ -ынх 0.55 м-т,  $-20^{\circ}$ -ынх 2-р сард 0.15 м тус тус илэрч байна. Хөрсний гүнд мөнх цэвдэггүй ба хүйтний улиралд 2.4 м хүрч хөлдөнө.

#### 5.1.9 Чийгшил, Тунадас, Ууршилт

Агаарын харьцангуй чийг газарзүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил нилээд дутмаг байдаг. Хүйтний улиралд агаарын харьцангуй чийгшил 71 %, харин дулааны улиралд 49 % байх ба жилийн явц нь өвөл, зун их утгаа авч хавар, намар хамгийн бага хэмжээтэй болдог. Уг бүс нутагт олон жилийн дундаж байдлаар 220-260 мм тунадас унах ба түүний 80-90 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу 5-9 дүгээр саруудад ордог байна. Анхны цас 10-р сарын сүүлчийн арав хоногт ажиглагдаж өвөл 5-10 см зузаан цасан бүрхүүл 110-150 хоног тогтож 4-р сарын дунд арав хоногт сүүлчийн цас ажиглагдах ба 3 дугаар сарын дундаас хайлж эхэлдэг. Цасны нягт 0.18 г/см<sup>3</sup> байдаг. Олон жилийн ажиглалтын материалаас үзэхэд хоногт орсон хамгийн их тунадас Өндөрхаанд 80.1мм 1996 онд, Баянмөнх харуулд 69.9 мм 1993 онд ажиглагдсан байна.

#### 5.1.10 Салхи

Тус районд баруун, баруун-хойт ба хойт зүгийн салхи зонхилох бөгөөд салхины хурд олон жилийн дунджаар 3.1-4.5 м/с байх ба 100 жилд тохиолдож болох салхины хурд 42 м/с байна.

#### 5.1.11 Цасан бүрхүүл


Манай орны газар нутгийн хотгор, гүдгэрийн ялгаанаас шалтгаалж цасны зузаан нь нутаг бүхэнд харилцан адилгүй байна. Цасан бүрхүүлийн зузааны горимыг цасны 10 хоногийн дундаж зузаан, цасны хамгийн их зузааны дундаж зэрэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Цасны хээрийн хэмжилтээр гаргасан 10 хоногийн дунджаас үзвэл уулархаг хэсэгт (уулсын хоорондох хөндий) 5 см ба түүнээс дээш, хээрийн бүсэд 5 см хүртэл, говьд 1-2 см-ээс төдийлөн хэтэрдэггүй байна.

Цасан бүрхүүлийн дундаж хамгийн их зузаан өндөр уулын бүсэд 30 см-ээс их, ойт хээрийн бүсэд 15-20 см, хээрт 10-15 см, говьд цасан бүрхүүл тогтсон үедээ 2-5 см (10 см-ээс бага) хүрдэг байна. Цасны зузааны хэмжилтийн олон жилийн мэдээгээр тухайн бүс нутагт тодорхой (5, 30, 50, 80 ба 95%) хангамжтай байх цасны зузааныг цаг уурч, эрдэмтэн Б.Жамбаажамцын судалснаар Монгол орны нутаг бүрт харилцан адилгүй байдаг байна. Халхын дундад ба Дарьгангын талархаг бүсэд байрлах Өндөрхаан станцад 5%-ийн хангамжтай байх цасан бүрхүүлийн зузаан 40 см байдаг байна.

Үзүүлэлт	Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил	
Агаарын дундаж температур		-23.5	-19.4	-9.2	2.6	10.8	16.9	19.1	16.9	9.7	0.5	-12.2	-20.6	-0.7	
Үнэмлэхүй их		2.0	2.9	19.9	29.9	31.6	36.5	36.8	37.8	29.9	27.1	16.0	0.7	37.9	
Үнэмлэхүй бага		-39.5	-39.7	-32.6	-21.0	-13.2	-3.6	0.1	-1.5	-10.5	-27.7	-35.4	-40.6	-40.6	
Хөрсний гадаргын температур		-23.3	-18.9	-6.7	5.6	15.7	21.8	23.6	21.0	13.0	2.3	-11.0	-20.1	1.9	
Үнэмлэхүй их		7.0	17.0	28.5	46.2	51.0	58.6	58.9	57.3	47.7	35.9	18.0	14.1	58.9	
Үнэмлэхүй бага		-41.6	-40.0	-38.4	-26.5	-19.5	-9.5	-1.0	-4.2	-14.0	-28.0	-39.2	-40.1	-41.6	
Хөрсний гүний температур	0.2	-11.9	-10.8	-5.1	2.3	9.7	15.4	18.5	17.7	12.4	5.0	-4.2	-9.1	3.3	
	0.4	-11.4	-10.0	-4.7	1.6	8.1	13.9	17.0	17.3	12.6	5.9	-2.5	-7.7	3.5	
	0.6	-8.8	-8.6	-4.3	6.4	6.1	11.1	15.0	15.7	11.9	6.5	-0.5	-6.1	3.2	
	0.8	-6.5	-7.0	-4.7	-0.7	3.8	9.0	9.0	12.6	14.1	11.5	1.2	-3.1	3.2	
	1.2	-3.5	-4.8	-3.8	-1.2	1.5	5.6	5.6	9.6	11.6	10.6	2.7	-1.1	2.2	
	1.6	-1.3	-2.6	-2.5	-1.3	-0.1	2.9	2.9	7.0	9.6	9.7	7.5	4.0	2.8	
	2.4	0.9	0	-0.7	-0.6	-0.3	0.5	0.5	3.5	6.7	7.9	7.2	5.2	2.7	
	3.2	2.2	1.2	0.4	0.2	0.4	0.4	0.7	2.9	5.9	7.3	7.2	5.9	3.2	
	30 <sup>0</sup> -аас халуун өдөр						1	3	6	3					13
	-40 <sup>0</sup> -аас хүйтэн өдөр	2													3
0 <sup>0</sup> -аас хүйтэн өдөр	31	26	28	21	8	1	1	0	1	3	18	30	30	198	
Хур тунадасны нийлбэр	1.3	2.7	2.6	8.0	15.1	48.6	73.2	69.9	23.6	23.6	8.4	3.5	2.6	259.4	
Хоногийн их тунадас	4.6	9.4	12.8	23.2	30.0	63.0	42.0	72.0	29.9	29.9	11.4	7.9	3.0	72.0	
Харьцангуй чийг, %	72	72	62	46	42	52	52	62	63	60	57	66	72	60	
Дутагдал чийгшил (мб)	0.3	0.6	2.0	4.7	7.6	8.7	8.7	7.0	6.0	4.6	3.0	1.3	0.4	3.8	
Салхины дундаж хурд (м/с)	3.5	3.5	3.9	4.9	4.7	3.9	3.9	3.2	3.0	3.4	3.4	3.5	3.5	3.7	
Хүчтэй салхитай өдөр (15м/с)				2	3									5	
Салхины хамгийн их хурд	17.0	17.0	20.0	22.0	20.0	17.0	17.0	8.0	17.0	14.0	17.0	17.0	20.0	22.0	

Хүснэгт 5.1. Өндөрхаан станцын уур амьсгалын үзүүлэлтүүд





Зураг5.2. Авто замын уур амьсгалын мужлал

Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи байдлаар үзүүлэв.

Хүснэгт5.2. Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	
IIB	1-9.XI 5.XI	19.II I	126-143 134	6-12.Y 9.Y	45-52 48	8-19.IX 13.I X	112-156 129	44-54 49

Хүснэгт5.3. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIB	+0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

Хүснэгт5.4. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
ИВ	20-30.X 25.X	15.II-30.IY 5.IY	120-195 160	15.III-10.IY 25.III	15.IY-31.Y 23.IY	20-50 35

Хүснэгт5.5. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүд

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
ИВ	10.IY	19.X	192	173

Хүснэгт5.6. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
ИВ	1.6-4.0	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

Хүснэгт5.7. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Дэд бүс	Хүчилтөрөгчийн нягт, г/см <sup>3</sup>	Хувцас хунарын дулаан чанар, КЛО(хүндэвтэр ажлыг нөхцөлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		Өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
ИВ	250-260	4.6-5.5	2.8-3.0	1.5-1.7	175-190	110-120	80-90

Хүснэгт5.8. Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
ИВ	1.00	1.00	1.00	1.00	1.00

*Хүснэгт5.9. Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа*

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIВ	18.IY-16.V (02. V)	15. VIII-19. IX (01.IX)	91-154 (122)

*Хүснэгт5.10. Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа*

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIВ	03. III-30.III (16. III)	30.X-04.XII (15.XI)	220-278 (250)

## 5.2 УС ЗҮЙ


### 5.2.1 Өмнө судлагдсан байдал

Хэнтий аймгийн Баянмөнх сумаас Хэрлэнгийн гүүр чиглэлийн төлөвлөж буй 93 км авто замыг хөндлөн гарах 90 хуурай сайр, гуу жалга, хөндийн хур борооны үерийн хамгийн их урсацын тооцоог холбогдох арга зүйн дагуу хийлээ. Эдгээр хуурай сайр, гуу жалга, хөндийн хур борооны урсацын тооцооноос зөвхөн төлөвлөж байгаа авто замтай хольцогдох хэсгийг оруулсан болно.

Эдгээр хуурай сайр, гуу жалга, хөндийнүүд нь голдрилын хэвгий багатай, ихэнх нь урдаас хойш чиглэлд замыг хөндлөн гарч Хэрлэн голд нийлдэг. Нуур, тойром, намаг үүсч болох талбайнуудад нуур, намагшлын итгэлцүүрийг 0.6-0.8 хэмээн авч тооцоонд ашигласан болно.

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт “Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм “/БНБД 2.01.14-86/ болон аман судалгаанаас үзэхэд зуны хур борооны үер нь хаврын шар усны үерээс илүү эрчимшилттэй байдаг тул хур борооны үерийн хамгийн их урсацын тооцоог гаргав. Хур борооны үерийн их урсацын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийх шаардлагатай байдаг. Иймд их урсацын тооцоог хийхдээ нэг хувийн хангамшилтай хоногийн их тунадасыг сүүлийн жилүүдэд барилга байгууламжийн тооцоонд хэрэглэж байгаа “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” БНБД 23-01-09-ийн (хуудас 122 зураг 29 -д) дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн

хангамшил бүхий хэмжээг уг бүсэд  $N_{1\%}=104$  мм гэж тодорхойлсон байдгаар цаашдын тооцоонд хэрэглэв.



29 дүгээр зураг. Монгол орны нэг хоногт орох хур тунадасны хангамжийн муж, мм

муж	хангамж, %						
	1	2	5	10	20	50	63
I	130	94	64	52	36	58	25
II	120	85	58	50	35	26	23
III	104	80	56	48	32	25	18
IV	140	75	50	40	30	20	17

Зураг 5.3 Хоногийн хамгийн их тунадасны мужлал

**Хамгийн их урсацын тооцоо:** Тухайн сав газар нь Монгол орны уруйн үер бага зэрэг болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Иймээс судалгаагүй сав газрын /гол, горхи, хуурай сайр/ хур борооны үерийн усны хамгийн их урсацын тооцоог дараах аргачлалуудаар тооцож гаргав.

Судалгаагүй жижиг гол, хуурай сайрын сав газрын хур борооны үерийн хамгийн их урсацыг хэд хэдэн аргаар тооцож болно. Эдгээрийн дотроос манай орны нөхцөлд тохирсон хур борооны хязгаарын эрчимшилийн аргаар уг сайрын ус хурах талбайд тохиох хур борооны хамгийн их урсацыг тодорхойлов. Энэ аргад тулгуурлан  $200 \text{ км}^2$ -аас бага ус хурах талбайтай жижиг гол, хуурай сайрын хур борооны хамгийн их өнгөрлтийг дараах томъёогоор тооцно.

$$Q_{1\%} = q_{1\%} \cdot \varphi \cdot N_{1\%} \cdot \sigma \cdot \lambda_{1\%} \cdot F \quad /1/$$

Үүнд:  $Q_{1\%}$  - 1% -ийн хангамшилтай өнгөрөлт

$q_{1\%}$  - 1% -ийн хангамшилтай их урсацын модуль, л/с  $\text{км}^2$

$\varphi$  - Урсацын итгэлцүүр

$N_{1\%}$  - 1% -ийн хангамшилтай хоногийн хамгийн их тунадас, мм

$\sigma$  - нууршилт, ойжилт, намагжилтын итгэлцүүр

$\lambda_{1\%}$  - 1%-ийн хангамшилаас бусад хангамшилд шилжүүлэх итгэлцүүр

$F$  - ус хурах талбай, км<sup>2</sup>

Урсацын хамгийн их модулийг /  $q_{1\%}$  / тодорхойлоход шаардагдах голдирлын хэлбэрзүйн /  $\Phi_r$  / болон ай савын хажуу бэлээр ус урсах хугацааг /  $t_{x6}$  / дараах томъёогоор тооцно.

$$\Phi_r = 1000 L / K_r J_r^k F^{1/4} (\varphi H_{1\%})^{1/4} \quad /2/$$

Үүнд:  $L$  - тухайн чиглэл хүртэлх үндсэн гол, сайрын урт, км

$K_r$  - голын голдирлын, татамын адраашлын итгэлцүүр

$J_r$  - гол ба сайрын дундаж хэвгий, ‰

Ус хурах талбайн хажуу бэлээр ус урсах хугацааг /  $t_{x6}$  / тодорхойлоход шаардагдах хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолтыг /  $\Phi_{x6}$  / доорх томъёогоор тооцно.

$$\Phi_{x6} = (1000 l)^{1/2} / n_{x6} J_{бэл}^{1/4} (\varphi H_{1\%})^{1/2} \quad /3/$$

$$l = F / 1.8 (\Sigma l + L) \quad /4/$$

Үүнд:  $l$  - ус хурах талбайн хажуу бэлийн дундаж урт, км

$n_{x6}$  - хажуу бэлийн адраашлын итгэлцүүр

$J_{бэл}$  - сав газрын дундаж хэвгий

$\Sigma l$  - сайруудын нийлбэр урт

Үерийн урсацын итгэлцүүрийг дараах томъёогоор тооцно.

$$\varphi = C_2 \varphi_0 / (F+1)^{n_6} (J_6/50)^{n_5} \quad /5/$$

Үүнд:  $C_2$  - хөрсний бүтэцээс хамаарах итгэлцүүр.

$\varphi_0$  -  $F=10$  км<sup>2</sup>,  $J_6 = 50$  байх үеийн урсацын итгэлцүүр.


$n_6$  - хөрсний бүтэцээс хамаарах итгэлцүүр.

$n_5$  - уур амьсгалаас хамаарах итгэлцүүр.

Янз бүрийн хангамшилтай их өнгөрөлтийг тооцоход тодорхой хангамшлын өнгөрөлт бүрд харгалзах голдрилын хэлбэрзүйн параметр, хажуу бэлийн хэлбэрзүйн параметр, түүгээр тодорхойлогдох ус хурах талбайн хажуу бэлээр ус урсах хугацаа, голдрилоор урсах хугацаа зэргийг тооцож хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт 5.11. Янз бүрийн хангамшилтай хамгийн их урсацын тооцооны хүснэгт


№	F (км <sup>2</sup> )	Lr (км)	Jr (‰)	lxб (км)	Ф	ФН <sub>1%</sub> (мм)	Фхб	t <sub>хб</sub> (мин)	Фг	q <sub>1%</sub> (л/сек.км <sup>2</sup> )	Q <sub>1%</sub> (м <sup>3</sup> /сек)	Q <sub>2%</sub> (м <sup>3</sup> /сек)	Q <sub>3%</sub> (м <sup>3</sup> /сек)	Q <sub>5%</sub> (м <sup>3</sup> /сек)
1	0.88	1.00	34	0.88	0.11	11.1	12.7	200	16.1	0.061	0.60	0.53	0.48	0.43
2	8.96	5.35	25	1.67	0.12	12.5	15.2	250	51.7	0.035	3.93	3.46	3.18	2.83
3	0.23	0.25	71	0.92	0.23	23.5	7.33	80	3.65	0.160	0.87	0.76	0.70	0.62
4	2.00	1.72	24	1.16	0.10	9.92	15.7	250	26.0	0.052	1.03	0.91	0.84	0.74
5	0.96	1.00	39	0.96	0.13	13.5	11.3	150	14.3	0.069	0.90	0.79	0.73	0.65
6	0.29	0.41	54	0.71	0.14	14.4	9.38	120	6.99	0.100	0.42	0.37	0.34	0.30



Зураг 5.4. Сайр, гуу жалга, хөндийнүүдийн ус хурах талбайн байдал /1:100 000/

### 5.2.2 Төлөвлөж буй авто замын урсацын тооцоо

Тооцоо хийж буй талбайнуудын хэмжээ, урт, тухайн талбай дахь зам, барилгажсан талбай, зүлэг, хашааны газрын эзлэх хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг Google-н зураг, Ханбогд сумын суурь зураг зэргийг ашиглан тодорхойлсон болно.



Зураг 5.5. Тооцоо хийсэн ус хурах талбайн сансрын зураг

Талбайнуудын борооны усны урсцын тооцоог “Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-014, Улаанбаатар, 2014 он”- д заасан дагуу хязгаарын эрчимшлийн дараах аргыг ашиглан тооцсон болно.

$$Q_r = z_{mid} * A^{1.2} F / tr^{1.2n-0.1}$$

Үүнд:

- $Q_r$  - борооны усны урсац, / л/с /
- $Z_{mid}$  - урсацын талбайн гадаргууг тодорхойлсон коэффициентийн дундаж утга
- $A_n$  - борооны эрчимшлийг илэрхийлэх параметрууд / БНД 40-01-14-д зааснаар авна/
- $tr$  - урсац үргэлжлэх хугацаа, мин
- $F$  - тооцоо хийж буй талбайн хэмжээ / га
- Урсац тооцох энэ аргад тухайн талбай дахь зам, барилга, зүлэг, ногоон байгууламж, хашаа зэргийн эзлэх талбайн хэмжээг тодорхойлон талбай тус бүрт нь тохирох газрын гадаргууг тооцсон коэффициентүүдийн жигнэсэн утгыг тооцдог болно.
- Урсацын тооцооны үр дүнг дараах хүснэгтэнд оруулав.

Хүснэгт 5.11. Ханбогд сумын авто замын талбайн ус хураах талбай, урсацын тооцооны үр дүн

№	Талбай, га	q20, л/с	n	A	Zmid	Tr, мин	Qr, л/с	$\beta$	Q cal, м3/с
1	82.7	50	0.41	170.76	0.064	7.17	1167.28	0.8	0.934
2	137.29	50	0.41	170.76	0.064	7.06	1949.52	0.8	1.560
3	11.7	50	0.41	170.76	0.064	7.15	165.29	0.8	0.132



## 6 БҮЛЭГ ЗУРГАА. ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 6.1 Хөдөлгөөн зохион байгуулалт

Замын тоноглол хөдөлгөөнийг зохион байгуулах зориулалт бүхий техник хэрэгслүүд буюу хашлага, хашилт, тэмдэг, тэмдэглэгээ, дохионы шон багтана.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохион байгуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор дараах ил харааны тэмдэгт, тэмдэглэгээг шаардлагатай газарт байрлуулахаар төлөвлөсөн. Замд тавигдах тэмдэг, тэмдэглэл, чиглүүлэлх хэрэгслүүдийн байрлал, тоо хэмжээ, төрөл, хэлбэр дүрсийг ажлын зурагт тодорхой үзүүлсэн болно.

### 6.2 Замын тоноглолд мөрдөх норм стандарт

Замын тоноглол нь дараах стандарт, техникийн шаардлагуудыг хангасан байна. Авто замын тоноглолын стандарт, техникийн баримт бичгүүд

- ✓ MNS 4912:2000 Авто замын тэмдэг болон дохионы төмөрбетон шон, техникийн шаардлага
- ✓ MNS ASTM C 76 M: 2004 Ус зайлуулах болон ариутгах татуургын төмөрбетон хоолой. Техникийн шаардлага
- ✓ MNS AASHTO M 180:2004 Авто замын долгионт төмөр хайс. Техникийн шаардлага
- ✓ MNS AASHTO M175M Нүхтэй бетон хоолой. Техникийн шаардлага
- ✓ MNS AASHTO M176M Сүвэрхэг бетон хоолой. Техникийн шаардлага
- ✓ MNS AASHTO M86M Бетон суваг, үерийн ус зайлуулах хоолойн техникийн шаардлага
- ✓ MNS ASTM D 4956:2005 Замын тэмдгийн гэрэл ойлгогч. Техникийн шаардлага
- ✓ MNS ASTM D 4071:2006 Төмөр бетон гүүрний гадаргууд ус тусгаарлах системийг хэрэглэх зөвлөмж
- ✓ MNS 842: 2006 Авто замын бетон ба төмөр бетон хашлага. Техникийн шаардлага
- ✓ MNS 4980:2000 Замын гэрлэн дохион ба үндсэн үзүүлэлтүүд
- ✓ MNS 4759:2003 Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага
- ✓ MNS 4597:2003 Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
- ✓ MNS 4596:98 Замын хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл хэрэглэх дүрэм.

Замын тэмдэг, тэмдэглэгээг БНБД 32-01-04, БНБД 32-01-07, БНБД 31-01-40, мөрдөж төсөллөсөн хэдий ч замын тэмдэг (МУҮС 4597-98: Замын тэмдэг, Техникийн ерөнхий шаардлагууд) тэмдэглэгээнд (МУҮС 4759-99: Замын тэмдэглэгээ, Техникийн ерөнхий шаардлагууд) мөрдөх Монголын үндэсний стандарт) MNS4980-2006 Замын гэрлэн дохио үндсэн үзүүлэлтүүд зэрэг Монголын үндэсний стандартыг удирдлага болгоно.



7 БҮЛЭГ ДОЛОО. УУЛЗВАР, ГАРЦ, ЗОГСООЛЫН ТӨЛӨВЛӨЛТ


7.1 Уулзвар, гарц

Хүснэгтб.1 Гарц, зогсоолын байрлал

№	Нэр	ПК+	Байрлал	Өнцөг	Эргэлтийн радиус
1	Гарц-1	0+585.000	зүүн	90°00'00"	15
2	Гарц-2	0+551.500	баруун	90°00'00"	15
3	Гарц-3	0+416.500	зүүн	90°00'00"	15
4	Гарц-4	0+280.000	баруун	90°00'00"	15
5	Гарц-5	0+250.000	баруун	90°00'00"	15
6	Гарц-6	0+250.000	зүүн	90°00'00"	15
7	Уулзвар-1	0+000.000	зүүн	104°00'00"	15
8	Уулзвар-2	0+489.189	баруун	87°00'00"	20
9	Уулзвар-3	0+664.030	зүүн	98°00'00"	15
10	Уулзвар-4	0+040.000	баруун	87°00'00"	15
11	Уулзвар-5	0+482.190	баруун	101°00'00"	15



Зураг7.1 Төлөвлөж буй орц, гарц/Гарц-5,6/



Зураг 7.2 Төлөвлөж буй уулзвар/Уулзвар-2/

## 7.2 Зогсоол


Авто замын трассын дагуу дараах байрлалуудад 110м урт жижиг – 42 машин, 120м урт жижиг-26 машин, 100м урт жижиг - 36 машин, том оврын 5 машин, 140м урт жижиг – 33 машины 4 зогсоолыг төлөвлөсөн. Үүнд:

- ✓ Зогсоол-1 ПК0+340.000 – ПК0+450.000
- ✓ Зогсоол-2 ПК0+120.000 – ПК0+240.000
- ✓ Зогсоол-3 ПК0+085.000 – ПК0+185.000
- ✓ Зогсоол-4 ПК0+120.000 – ПК0+260.000

Нарийвчилсан зураг төслөөс зай хэмжээ болон тэмдэг, тэмдэглэлийн байршил зэргийг харна уу. 3D зургийг Зураг 6.3, 6.4, 6.5, 6.6-аас харна уу.




Зураг 7.3 Төлөвлөж буй зогсоол-1



Зураг 7.4 Төлөвлөж буй зогсоол-2



Зураг 7.5 Төлөвлөж буй зогсоол-3



Зураг 7.6 Төлөвлөж буй зогсоол-4

## 8 БҮЛЭГ НАЙМ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Зам барилгын талбай дээр ажиллаж буй бүх ажилчид, ИТА нар нь МУ-ын ХАБЭА-н тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, байгууллагын дотоод журам болон эдгээртэй холбогдон гарсан тушаал, шийдвэр, захирамжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Барилгын үйл ажиллагаа явуулж буй байгууллага нь дараах ажлуудыг хийх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн сайдын А/114 тоот тушаалын дагуу ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөл /орон тооны бус/ байгуулан ажиллах
- ✓ Монгол улсын засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 269 дугаар тогтоолын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс /орон тооны бус/ байгуулах
- ✓ ХАБЭА-н асуудал хариуцсан инженерийг томилох
- ✓ ХАБЭА-н тухай хуулийн дагуу ажилчид, ИТА нарыг ажлын тусгай хувцас, хэрэгслээр хангах
- ✓ Ажилчид, ИТА нарт ХАБЭА-н сургалт зохион байгуулах
- ✓ Гал унтраах тоноглол ашиглах, анхны тусламж үзүүлэх, чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах
- ✓ ХАБЭА-н талаар хийсэн ажлын мэдээг тайлагнах, бүртгэх
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм ЗЗБНБД 15-002-2016 мөрдөж ажиллах

### 8.1 Сургууль орчмын бүсийн хөдөлгөөний аюулгүй байдал

Сургууль орчмын бүсэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс дараах зүйлсийг баримтална. Үүнд:

1. Сургууль орчмын бүс болон ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн ойр орчимд хэрэглэх анхааруулах болон мэдээллэх тэмдэг, хурдны хязгаар заасан тэмдэг нь MNS 4596:2014, MNS 4597:2014 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна. "СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС" ойртож байна тэмдгийг тал бүрт сургуулийн бүсээс өмнө дор хаяж 200м-ийн наана байрлуулна.
